

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖИЙН 2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 02 дугаар сарын 28

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1.	2021.02.11	2021.02.10	A/85	Захирамжийн хэрэгжилтийг ханган 3 дахь заалтын дагуу 2021 оны 02 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд Багануур дүүргийн нийт 5 хороонд зохион байгуулсан "Нэг хаалга-Нэг шинжилгээ" үйл ажиллагаанд байгууллагын 12 албан хаагчдаас 0-3 насны хүүхэдтэй 2 албан хаагчийг чөлөөлж, нийт 10 ажилтанг оролцуулж, шинжилгээнд хамрагдаж буй өрх, хүний тоонд явцын хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэн өдөр бүрийн 12.00 болон 16.00 цагуудад нийслэлийн шуурхай штабт, 12.00 болон 16.00, 20.00 цагуудад дүүргийн Онцгой комиссын шуурхай штаб болон ЭМН-ийн дэргэдэх ШШ-т тус тус мэдээлж, НЗДТГ-т албан бичгээр илтгэх хуудас, цахим хаягаар уг арга хэмжээнд оролцсон албан хаагчдын мэдээллийг тус тус хүргүүлсэн.
2.	2021.02.11	2021.02.10	A/86	Захирамжийн 2 дахь заалтын дагуу Албан хаагчид хүнсний бүтээгдэхүүнээ нөөцлөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд гэрээсээ гаралгүй хөл хорионы дэглэмийг чанд баримтлан хэрэгжилтийг ханган ажилласан.
3.	2021.02.11	2021.02.10	A/87	Захирамжийн 6 дахь заалтын хэрэгжилтийг ханган үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах үүднээс паркийн удирдлага, нягтлан бодогчийн хамт ажлын байранд, үлдсэн ажилчдыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэн халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан ажилласан. Манай байгууллагын ажилтнууд болон ар гэрийнхэнд ковид-19 халдварын ямар нэгэн өвчний шинж байхгүй болно.
4.	2021.02.26	2021.02.22	A/108	Захирамжийн 2 дахь заалтын дагуу "Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Э. Энхзаяа* Э.ЭНХЗАЯА